



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 114.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Ялаас чөлөөлөх өвчний жагсаалтыг нэгдүгээр, хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалыг улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж, мөрдөн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газар, Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Аймгийн эрүүл мэндийн газрын захирал, дарга нарт даалгасугай

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

081479

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 10 сарын 15 өдрын
416 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЯЛААС ЧӨЛӨӨЛӨХ ӨВЧНИЙ ЖАГСААЛТ,

Нэг. Нийтлэг үндэслэл


1.1 Эрүүгийн хуулийн 75 дугаар зүйлийн 75.3, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 333 дугаар зүйл, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 114.3, 134.2.3 дугаар зүйлүүдийг үндэслэн ялтныг өвчний учир ялаас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү жагсаалтыг ашиглана.

Хоёр. Ялаас чөлөөлөх өвчний жагсаалт

2.1 Ялтан дор дурдсан өвчнөөр хүнд өвчилж эд эрхтэний эргэшгүй өөрчлөлтийн улмаас хүний асрамжинд орсон үед ялаас чөлөөлөх өвчнөөр өвдсөн гэж үзнэ.

- 2.1.1 Цусны эсийн хорт хавдар,
- 2.1.2 Цус төлжихгүй болсон цус багадалт,
- 2.1.3 Үргэлжилсэн уналт, таталтын байдал /эпилепси статус/, хоёроос дээш эмэнд дасалтай эпилепси,
- 2.1.4 Чихрийн шижин өвчний хүндрэл, эрхтэн тогтолцоонд гүнзгий өөрчлөлт гарах,
- 2.1.5 Холбогч эдийн тогтолцооны өвчний хүндрэл, эрхтэн тогтолцоонд гүнзгий өөрчлөлт гарах,
- 2.1.6 Үе барьцалдсанаас өөртөө үйлчилж чадахгүй болсон /Окороковын үйл ажиллагааны ангилалын III үе, Бейнклерийн ангилалын IV үе/,
- 2.1.7 Олдмол ухаан тэнэгрэлийн хүнд хэлбэр, /F00, F01, F02, F03/,
- 2.1.8 Үлдэц шизофрени /сэтгэцийн нэгдмэл үйл задрах эмгэгийн тасралтгүй болон дефект улам нэмэгдэх хандлагатай үе үе хөдлөх шизофрени /F20.50, F20.51/
- 2.1.9 Хөгшрөлтийн улмаас өөртөө үйлчлэх чадвар алдагдсан, бусдын асрамжинд орсон,
- 2.1.10 Тархи, нуруу нугас, хязгаарын мэдрэлийн дарагдал, үрэвслийн хүнд хэлбэр /бусдын асрамжинд орох/:
 - 2.1.10.1 Сөнөрөлд өртсөнөөс үүссэн хос, тал саа,
 - 2.1.10.2 Дөрвөн мөчийн саажилт,
 - 2.1.10.3 Аарцгийн үйл ажиллагааны хямрал /баас, шээс хоригдох эсвэл задгайрах.

- 2.1.11 Хоёр гар оролцон гурван мөч, эсхүл дөрвөн мөчийг өвдөг, тохойн үеээс дээгүүр тайрагдсан,
- 2.1.12 Хоёр нүд сохрох,
- 2.1.13 Өмөнгийн 3-4 дүгээр үе,
- 2.1.14 Ясны идээт үрэвслийн улмаас эрүүг мэс заслаар авсан тохиолдол,
- 2.1.15 Гэмтэл болон өвчний улмаас үүссэн амин эрхтний үйл ажиллагааны дутмагшил:
- 2.1.15.1 Тархины комын байдалтай,
- 2.1.15.2 Цусны эргэлтийн архаг дутмагшлын II-III үе,
- 2.1.15.3 Амьсгалын архаг дутмагшлын II-III үе,
- 2.1.15.4 Элэгний архаг дутмагшлын II-III үе,
- 2.1.15.5 Бөөрний архаг дутмагшлын II-III үе,
- 2.1.15.6 Гэдэсний архаг дутмагшлын шувтаргын үе /нарийн, бүдүүн гэдэсний архаг өвчний улмаас 21 хоногоос дээш мэдээгүй суулгаж тураалын III-IV зэрэгт орсон бол/,
- 2.1.15.7 Олон эрхтний архаг дутмагшил.
- 2.1.16 Сүрьеэгийн хүнд хэлбэрүүд нь сүрьеэгийн эмчилгээний эсрэг заалт бүхий өвчнүүдтэй хавсарсан тохиолдол:
- 2.1.16.1 Элэгний циррозийн ээнэгшил алдагдсан үе,
- 2.1.17 Сүрьеэгийн менингитийн улмаас мөчдийн саажилт үүссэн өвчтөн бусдын асрамжид орох,
- 2.1.18 Хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ)-ийн халдварын IV үе шат (ДОХ) дараах өвчний амь насанд аюултай үе шат хавсарсан:
- 2.1.18.1 ДОХ уялдаат өвчин,
- 2.1.18.2 Дагалдах халдвар,
- 2.1.18.3 Суурь өвчин.



2.2 Энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан өвчнийг дараах шинжилгээ, оношилгоогоор баталгаажуулна.

Д/д	Өвчний нэр	Шалгуур
1.	Цусны эсийн хорт хавдар	- Гематологийн шинжилгээнд залуу эсүүд гарах - Цус, чөмөгний түрхэцийн шинжилгээ
2.	Цус төлжихгүй болсон цус багадалт	- Цусны түрхэц шинжилгээ /+/ - ЦЕШ
3.	Үргэлжилсэн уналт таталтын байдал, хоёроос дээш эмэнд тэсвэртэй эпилепси	- Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг - ЭКГ - Толгойн КТГ - Хүчил шүлтийн тэнцвэр - Тархины цахилгаан бичлэг /агшин болон унталтын үеийн/


4.	Чихрийн шижин өвчний хүндрэл, тогтолцоонд өөрчлөлт гарах эрхтэн гүнзгий	<ul style="list-style-type: none"> - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, дүгнэлт - ЦЕШ - ШЕШ - ЭКГ - Глюкозжижсан гемоглобин - Нүдний уг харах - Биохимийн холбогдох үзүүлэлтүүд - Давамгайлсан гэмтсэн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг үнэлэх нарийвчилсан шинжилгээ, төрөлжсөн мэргэжлийн үзлэг дүгнэлт
5.	Холбогч эдийн тогтолцооны хүндрэл, эрхтэн тогтолцоонд гүнзгий өөрчлөлт гарах өвчний	<ul style="list-style-type: none"> - Эрхтэн тогтолцоог үнэлэх лабораторийн болон багажийн шинжилгээ - Иммунологийн эсрэгбие шинжилгээ - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, дүгнэлт - Давамгайлсан гэмтсэн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааг үнэлэх нарийвчилсан шинжилгээ, төрөлжсөн мэргэжлийн үзлэг дүгнэлт
6.	Үе барьцалдсанаас өөртөө үйлчилж чадахгүй болсон үе /Окороковын үйл ажиллагааны ангилалын III үе, Бейнклерийн ангилалын IV үе/	<ul style="list-style-type: none"> - Үений рентген зураг - Үений КТ, шаардлагатай бол MRI - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, дүгнэлт - Ясны нягтын шинжилгээ
7.	Олдмол ухаан тэнэгрэлийн хүнд хэлбэр /F00, F01, F02, F03/	<ul style="list-style-type: none"> - Сэтгэцийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг - Эмгэг сэтгэл судлалын шинжилгээ - Шаардлагатай тохиолдолд тархины багажийн шинжилгээ /КТГ, MRI, рентген зураг./ - Шүүх сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээний үнэлгээ дүгнэлт
8.	Үлдэц шизофрени /сэтгэцийн нэгдмэл үйл задрах эмгэгийн тасралтгүй болон дефект улам нэмэгдэх хандлагатай үе үе хөдлөх шизофрени /F20.50, F 20.51/	<ul style="list-style-type: none"> - Шүүх сэтгэц эмгэг судлалын магадлан шинжилгээний үнэлгээ дүгнэлт - Эмгэг сэтгэл судлалын шинжилгээ
9.	Хөгшрөлтийн улмаас өөртөө үйлчлэх чадвар алдагдсан, бусдын асрамжинд орсон	<ul style="list-style-type: none"> - Сэтгэцийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг - Настны бие даах чадварын Катзын үнэлгээ / 9-0 балл / - Настны багаж хэрэгсэлтэй ажиллах

		<p>чадварын лавтоны үнэлгээ /13-6 балл /</p> <ul style="list-style-type: none"> - Настны сэтгэцийг үнэлэх хураангуй сорил буюу 30 онооны ММЕТ /13-6 балл/ - Настны сэтгэл гутралыг үнэлэх сорил, 15 асуулттай /5 ба түүнээс дээш оноо/
10.	<p>Тархи, нуруу нугас, хязгаарын мэдрэлийн дарагдал, үрэвслийн хүнд хэлбэр /бусдын асрамжинд орох/</p> <ul style="list-style-type: none"> • сөнөрөлд өртсөнөөс хос, тал саа, • дөрвөн мөчийн саажилт, • аарцгийн үйл ажиллагааны хямрал /баас, шээс хоригдох эсвэл задгайрах 	<ul style="list-style-type: none"> - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг - Тухайн эрхтний КТГ - Нүдний уг харах - MRI шинжилгээгээ
11.	<p>Хоёр гар оролцон гурван мөч, эсхүл дөрвөн мөчийг өвдөг, тохойн үеээс дээгүүр тайрагдсан</p>	<ul style="list-style-type: none"> - Рентген зураг - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, дүгнэлт
12.	<p>Хоёр нүд сохрох</p>	<ul style="list-style-type: none"> - Нүдний төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээ, дүгнэлт
13.	<p>Өмөнгийн 3-4 дүгээр үе</p>	<ul style="list-style-type: none"> - Хавдарын маркер - Эд, эсийн шинжилгээ - Тухайн эрхнийн КТГ - Биохими - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, дүгнэлт
14.	<p>Ясны идээт үрэвслийн улмаас эрүүг мэс заслаар авсан тохиолдол</p>	<ul style="list-style-type: none"> - Гавлын рентген зураг - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, дүгнэлт
15.	<p>Гэмтэл болон өвчний улмаас үүссэн амин эрхтний үйл ажиллагааны архаг дутмагшил</p>	<ul style="list-style-type: none"> - Холбогдох шинжилгээ, төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг Комын байдлыг үнэлэхдээ - Ухаан санааны үнэлгээ /3-8 балл/ - Цусны дэлгэрэнгүй шинжилгээ - Биохимийн үзүүлэлтүүд - Протромбины хугацаа - Цусны өсгөвөр - ЭКГ - Цээжний рентген зураг - КТГ - Нугасны ус - Хэвлийн хэт авиан шинжилгээ

		<ul style="list-style-type: none"> - Тархины доплер - Тархины цахилгаан бичлэг
16.	<p>Сүрьеэгийн хүнд хэлбэрүүд нь сүрьеэгийн эмчилгээний эсрэг заалт бүхий өвчнүүдтэй хавсарсан тохиолдол:</p> <ul style="list-style-type: none"> • Элэгний циррозийн ээнэгшил алдагдсан үе 	<ul style="list-style-type: none"> - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, дүгнэлт - Хэвлийн ЭХО - Рентген зураг - ЦЕШ - Цэрний түрхэц - Микобактери илрүүлэх шинжилгээ - Биохими - Хепатитийн вирусийн маркер
17.	<p>Сүрьеэгийн менингитийн улмаас мөчдийн саажилт үүссэн өвчтөн бусдын асрамжид орох,</p>	<ul style="list-style-type: none"> - Сүрьеэгийн эмчийн үзлэг - Мэдрэлийн эмчийн үзлэг - Рентген зураг - Тархи, нугасны шингэний шинжилгээ - ЦЕШ - Биохими
18.	<p>Хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ)-ийн халдварын IV үе шат (ДОХ) дараах өвчний амь насанд аюултай үе шат хавсарсан:</p> <ul style="list-style-type: none"> • ДОХ уялдаат өвчин • Дагалдах халдвар • Суурь өвчин 	<ul style="list-style-type: none"> - Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг - CD4 эсийн тоо - ХДХВ-ийн ачаалал - Бусад дагалдах халдварын лабораторийн шинжилгээ - ЦЕШ - Биохими - Хэвлийн ЭХО



Эрүүл мэнд, Спортын сайдын
2015 оны 10 сарын 15 өдрийн
4/6 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



Хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хорих ангид ял эдэлж буй хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалт

2.1 Хорих анги, Шийдвэр гүйцэтгэх албатай байгуулсан гэрээний дагуу хүнд өвчтэй ялтанд харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллага дараах эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

2.1.1 Хорих ангийн дуудлагаар түргэн тусламж болон яаралтай тусламжийн үйлчилгээ,

2.1.2 Хорих анги, Шийдвэр гүйцэтгэх албатай байгуулсан гэрээний дагуу эрүүл мэндийн байгууллага төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлэх,

2.1.3 Ялтан нас барсан тохиолдолд орон нутгийн шүүхийн шинжилгээний алба, хэсгийн шинжээч эмч шүүх эмнэлгийн задлан шинжилгээг хийж дүгнэлт гаргах,

2.1.4 Ялтны хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох асуудлыг эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын үйл ажиллагааны зааврын дагуу шийдвэрлэх.

2.2 Ялтанд ялаас чөлөөлөх өвчний шинж илэрвэл хорих анги, Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн эмнэлэгт мэдэгдэж, ялтны биеийн байдлыг харгалзан ажлын 5 хоногийн дотор Тогтоолын нэгдсэн эмнэлэгт өвчтөн шилжүүлэх журмын дагуу шилжүүлнэ.

2.3 Шилжүүлэх боломжгүй тохиолдолд дээрх хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, мэс заслын тасгийн эрхлэгч, онош зүйн тасгийн эрхлэгч, нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй хяналтын комисс газар дээр нь очиж үзлэг хийж дүгнэлт гаргана.

2.4 Нэгдсэн эмнэлэг энэ журмын 2.2-т заасны дагуу шилжиж ирсэн ялтанд төрөлжсөн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийж, ялаас чөлөөлөх өвчнөөр өвчилсөн нь тогтоогдвол эмчлэгч эмч энэ тухай үнэн зөв баримтыг бүрдүүлж нэгдсэн эмнэлгийн хяналтын комисст нэн даруй хүргүүлнэ.

2.5 Нэгдсэн эмнэлгийн эмч нарын хяналтын комисс энэ журмын 2.4-д заасны дагуу шилжүүлсэн баримтыг үндэслэн ялаас чөлөөлөх өвчний жагсаалтын 2.2-д заасан шинжилгээ, оношийг дахин нягталж ялтны биеийн байдлыг бүрэн бүрэлдэхүүнээрээ газар дээр нь үзэж дүнг хурлаар хэлэлцэж санал нэгдвэл хурлын тэмдэглэлд бүх гишүүд гарын үсэг зурж, ялаас чөлөөлөх санал, эрүүл мэндийн тодорхойлолт, ялтны хувийн хэрэг, ялын тооцоог Тогтоол гүйцэтгэх газраар дамжуулж прокурорт хүргүүлнэ.

2.6 Прокурор нь энэ журмын 2.5 дахь заалтад заасны дагуу шилжүүлсэн баримтыг хянан үзэж саналыг үндэслэлтэй гэж үзвэл Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 333 дугаар зүйлийн 333.1-д заасан комиссийн дүгнэлт гаргуулна.

2.7 Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 333 дугаар үйлийн 333.1. дүгээр зүйлд заасны дагуу томилогдсон комисс ял эдлүүлэх боломжгүй гэсэн дүгнэлт гаргавал шүүгч Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 333 дугаар зүйлийн 333.2-д зааснаар захирамж гаргана.

2.8 Энэ журам нь Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 333 дугаар зүйлийн 333.3-д заасан ялтанд хамаарахгүй.

Гурав. Хүнд өвчтэй ялтанд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд ял эдэлж байгаа ялтны хорих ангийн үүрэг

Ялтанд энэ журмын 2-т заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хорих анги дараах үүрэг хүлээнэ.

3.1 Хорих анги эмчлэх эрх бүхий эмнэлгийн мэргэжилтэнтэй байх ба үзлэг, оношилгоо, эмчилгээ хийх зориулалтын өрөөтэй байна.

3.2 Хорих ангийн эмч анхны тусламжийн болон амилуулах суурь тусламжид шаардлагатай өрөө, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл эм, тариагаар хангагдсан байна.

3.3 Ялтны биеийн байдлын талаар Тогтоол гүйцэтгэх газарт урьдчилан танилцуулах,

3.4 Ялтны эрүүл мэндийн даатгалын дэвтрийн бүрдлийг хангаж, хураамжийг хариуцах,

3.5 Ялтны ялаас чөлөөлөх өвчнийг баталгаажуулах шинжилгээ, оношилгоог үзүүлэхэд шаардагдах төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг ял эдэлж байгаа ялтны хорих анги нь хариуцах,

3.6 Ялтан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, харуул хамгаалалтыг зохион байгуулах,

3.7 Ялтан зөрчил гаргавал хувийн хэрэгт нь тэмдэглэн эмчлэгч эмчийн саналыг үндэслэн эмнэлгээс гаргана.

3.8 Гэрээ байгуулсан эмнэлэгт ялтны эмчилгээний ор хоног дуусаж эмчилгээг үргэлжлүүлэн нэгдсэн эмнэлэг, хорих ангийн эмнэлэгт хийх боломжтой талаар эмчийн дүгнэлтийг үндэслэн тухайн эмнэлэгт шилжүүлэх,

3.9 Ялтанг эмнэлгээс гарахад эмнэлгээс өвчтөн илгээх хуудсыг дэлгэрэнгүй бичүүлж авах,

3.10 Ялтны биеийн байдал хүнд, эсхүл мэс засал хийлгэснээс бусдын асаргаа, сувилгаа зайлшгүй шаардлагатай бол ар гэрийнхний хүсэлт, эмчлэгч эмчийн саналыг үндэслэн хорих ангийн даргын шийдвэрээр сахиулах.

